

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ДҮРМИЙН ТАНИЛЦУУЛГА

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30.2-д заасны дагуу Засгийн газрын тогтоолоор батлахаар хуульчилсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолоор батлуулсан.

Дүрмийн хэрэгжилтийн явцад холбогдох нэмэлт өөрчлөлт, сайжруулалт оруулах шаардлагууд тулгараад байгаа бөгөөд жишээлбэл, Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн ангилалд хамаарах барилга байгууламжид эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулахад зарим аймаг, орон нутагт байгууллагын орон тоо, инженер техникийн ажилчид дутмаг байдлаас болж шийдвэрлэх боломжгүй байгаа талаарх хүсэлтийг тус яаманд удаа дараа ирүүлэх асуудал тулгардаг. Мөн эрчим хүчний салбарын барилга байгууламжид эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохдоо Эрчим хүчний сайдын 2018 оны 92 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ыг мөрдөж байгаа нь Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хуульд нийцэхгүй байгаа юм.

Тус шинэчлэн боловсруулсан дүрмийн төслөөр Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 20 дугаар зүйлийн 20.2-д, 32 дугаар зүйлийн 32.1.5-д хамаарах барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа техникийн комисс ажилласны үндсэн дээр барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ашиглалтад оруулах комисс ажиллах зарчмыг тусгасан. Техникийн комисс ажиллуулснаар гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт бүрэн хангагдсаны дараа ашиглалтад оруулах комисс цомхон бүрэлдэхүүнтэй ажиллаж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах боломжтой болно.

Энэхүү зарчим нь гүйцэтгэл нь бүрэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах, үүрэг даалгаврын биелэлтийг хянах нөхцлийг бүрдүүлж, чанарын хяналтыг нэг шатаар ахиулах боломжийг бүрдүүлж байгаа юм. Түүнчлэн, томоохон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, барилга байгууламжуудыг нэгдсэн удирдлага, төлөвлөлтөд оруулах юм.

Уг дүрмийг төслийг батлах төслийг аймаг, нийслэлийн барилгын асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудад цахим хэлбэрээр, болон салбарын төрийн бус байгууллагуудад тус тус танилцуулж хэлэлцүүлгийн мөрөөр ирүүлсэн саналуудыг тусгасан болно.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ**

2021 оны . . . дугаар
сарын –ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдсан барилга байгууламжийг Барилгын тухай хуульд заасны дагуу ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулахад Барилгын тухай хуулийн 48¹ дугаар зүйлд заасныг болон энэхүү дүрмийг баримтална.

1.3. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1²-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулахад энэхүү дүрэм хамаарахгүй ба барилгын ажлын захиалагч (цаашид “захиалагч” гэх) шаардлагатай тохиолдолд энэхүү дүрмийг жишиг болгон мөрдөж болно.

Хоёр. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргах

2.1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргахдаа захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч хамтран барилга байгууламжид үзлэг хийж, зөрчлийг арилгуулж, Барилгын тухай хуулийн 48.5.3³, 48.5.4⁴-т тус тус заасан дүгнэлтийг гаргасан байна.

2.2. Захиалагч барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтэд Барилгын тухай хуулийн 48.5.5-д заасан инженерийн хангамжийн байгууллагын баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээллийг хавсаргасан байна.

2.3. Захиалагч барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтэд Барилгын тухай хуулийн 48.5-д заасан баримт бичгийг хавсаргах бөгөөд уг баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зааврын дагуу хөтөлж бүрдүүлсэн байна.

2.4. Захиалагч барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтээ барилга байгууламжийн төвөгшлийн ангилалаас хамааран барилгын ажлын зөвшөөрөл олгосон дараах байгууллагуудад хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2⁵, 32 дугаар зүйлийн 32.1.5⁶-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах

¹ 48 дугаар зүйл. Барилга байгууламж ашиглалтад оруулах

² 10.1.1. барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж;

³ 48.5.3. зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

⁴ 48.5.4. захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт;

⁵ 20.2. Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгоно.

⁶ 32.1.5. цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой, газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолой зэрэг улсын чанартай барилга байгууламжид барилгын ажлын зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх;

хүсэлтээ барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

2.4.2. Засгийн газрын 2021 оны ... тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн 2.3-т зааснаар барилгын ажлын зөвшөөрөл авсан тохиолдолд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

2.4.3. энэхүү дүрмийн 2.4.1, 2.4.2-т зааснаас бусад барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтээ аймаг, нийслэлийн Засаг даргад.

Гурав. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах

3.1. Захиалагчийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг ашиглалтад оруулах байгууллага хүлээн авч, Барилгын тухай хуулийн 48.5-д заасан баримт бичгийн бүрдэлийг хянаж, шаардлага хангасан бол барилга байгууламжийн төвөгшлийн ангилалаас хамааруулан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг дараах байдлаар тус тус томилно.

3.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга захиалагчийн хүсэлтийг хүлээн авч дараах байдлаар комиссыг томилно. Үүнд:

3.2.1. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2⁷, 10.1.3⁸, 10.1.4⁹-т хамаарах барилга байгууламжийн хувьд энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтад заасан бүрэлдэхүүнтэй ашиглалтад оруулах комиссыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулан ажиллуулна;

3.2.2. Барилгын тухай хуулийн 10.1.5¹⁰-д хамаарах барилга байгууламжийн хувьд энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтад заасан бүрэлдэхүүнтэй ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах эсхүл барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлтийг уламжлан шийдвэрлүүлнэ;

3.2.3. барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажил хийсэн тохиолдолд энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтын 2 дахь заалтад заасан бүрэлдэхүүнтэй ашиглалтад оруулах комиссыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулан ажиллуулна.

3.3. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтын 3 дахь заалтад заасан техникийн комисс ажиллуулж, дүгнэлт гаргасны үндсэн дээр ашиглалтад оруулах комиссыг энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтын 4 дэх заалтад заасан бүрэлдэхүүнтэй ашиглалтад оруулах комисс байгуулан ажиллуулна.

⁷ 10.1.2. бага төвөгшилтэй барилга байгууламж;

⁸ 10.1.3. дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж;

⁹ 10.1.4. өндөр төвөгшилтэй барилга байгууламж;

¹⁰ 10.1.5. онцгой төвөгшилтэй барилга байгууламж.

3.4. Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгууллага энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтын 5 дахь заалтад заасан техникийн комисс ажиллуулан дүгнэлт гаргуулж, уг дүгнэлтийг хавсарган барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

3.5. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү дүрмийн 3.4-т заасан хүсэлтийг үндэслэн, дүрмийн 1 дүгээр хавсралтын 6 дахь заалтад заасан бүрэлдэхүүнтэй ашиглалтад оруулах комисс ажиллуулна.

3.6. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан барилга байгууламжийг аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ашиглалтад оруулах тохиолдолд энэхүү дүрмийн 3.4, 3.5-д заасны дагуу ажиллуулна.

Дөрөв. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа, түүний чиг үүрэг

4.1. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 32 дугаар зүйлийн 32.1.5-д хамаарах ангилалын барилга байгууламжийн хувьд ажиллах урьдчилсан дүгнэлт гаргах үүрэг бүхий техникийн комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. барилгын ажлын гүйцэтгэлийг захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлттэй уялдуулан хянаж дүгнэх;

4.1.2. барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг Барилгын тухай хуулийн 40.1.11¹¹, 40.1.12¹²-т заасан баримт бичиг, лабораторын шинжилгээний дүгнэлт болон захиалагчийн баталгаажуулалтад үндэслэн хянаж дүгнэх;

4.1.3. хүрээлэн байгаа орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан эсэхийг дүгнэх;

4.1.4. барилга байгууламжид суурилагдсан өргөх байгууламж болон тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээнд туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдлыг шалгаж, ашиглах боломжтой эсэхийг дүгнэх;

4.1.5. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан эсэхийг дүгнэх;

4.1.6. барилгын ажлын явцад барилгын улсын техникийн хяналт хэрэгжүүлэх байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдлыг дүгнэх;

¹¹ 40.1.11. барилга байгууламжид хэрэглэгдсэн материал, тоног төхөөрөмж, зураг төсөлд заасан техникийн үзүүлэлтийг хангаж байгааг нотлох, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

¹² 40.1.12. барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

4.1.7. Барилгын тухай хуулийн 48.5-д заасан баримт бичгийн шаардлага хангасан эсэхийг хянах.

4.2. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 32 дугаар зүйлийн 32.1.5-д хамаарах ангилалын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1. техникийн комиссын дүгнэлт, түүний шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалыг арилгасан эсэхийг хянах;

4.2.2. Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан барилгын үйл ажиллагааны зарчим хангагдсан эсэхийг дүгнэх;

4.2.3. комисс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд барилга байгууламжийн хэвийн үйл ажиллагаатай холбоотой бусад баримт бичгийг нэмж тодруулж болно.

4.3. Энэхүү дүрмийн 2.4.3-т заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ . Үүнд:

4.3.1. барилгын ажлын гүйцэтгэлийг захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлттэй уялдуулан хянаж дүгнэх;

4.3.2. барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг Барилгын тухай хуулийн 40.1.11, 40.1.12-т заасан баримт бичиг, лабораторын шинжилгээний дүгнэлт болон захиалагчийн баталгаажуулалтад үндэслэн хянаж дүгнэх;

4.3.3. хүрээлэн байгаа орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан эсэхийг дүгнэх;

4.3.4. барилга байгууламжид суурилагдсан өргөх байгууламж болон тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээнд туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдлыг шалгаж, ашиглах боломжтой эсэхийг дүгнэх;

4.3.5. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан эсэхийг дүгнэх;

4.3.6. барилгын ажлын явцад барилгын улсын техникийн хяналт хэрэгжүүлэх байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдлыг дүгнэх;

4.3.7. Барилгын тухай хуулийн 48.5-д заасан баримт бичгийн шаардлага хангасан эсэхийг хянах;

4.3.8. Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан барилгын үйл ажиллагааны зарчим хангагдсан эсэхийг дүгнэх;

4.3.9. комисс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд барилга байгууламжийн хэвийн үйл ажиллагаатай холбоотой бусад баримт бичгийг нэмж тодруулж болно.

4.4. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан барилга байгууламжийг аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ашиглалтад оруулах тохиолдолд энэхүү дүрмийн 4.1, 4.2-т заасны дагуу ажиллуулна.

Тав. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болон техникийн комиссын ажиллах зарчим

5.1. Комиссын нарийн бичгийн дарга захиалагчтай хамтран комиссын хуралдааны бэлтгэлийг хангуулж, гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хуралдаан зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, дүгнэлт үйлдэх ажлыг хариуцна.

5.2. Комиссын нарийн бичгийн дарга баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан бол комисс ажиллуулах мэдэгдэлийг комиссын гишүүдэд тараана.

5.3. Комиссын нарийн бичгийн дарга нь комиссын хурлыг зохион байгуулах, гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хурлын тэмдэглэл хөтөлж, дүгнэлтийг баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

5.4. Комиссын нарийн бичгийн дарга нь комиссын гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэлийн хуудсыг заавал бөглүүлж авна.

5.5. Барилгын ажлын зөвшөөрлийн нөхцөлүүдийг зөрчсөн, захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтэд заасан шаардлагууд хангагдаагүй гэж үзэх үндэслэл байгаа, эсхүл холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөлийг хангаагүй, эсхүл холбогдох баримт бичгийн бүрдэл хангагдаагүй гэж үзсэн тохиолдолд барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзаж, захиалагчийн хүсэлтийг буцаана.

5.6. Комиссын хуралдааныг гишүүд нь 90 хувиас доошгүй ирцтэй зохион байгуулна. Комиссын хуралд хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй гишүүн хурлаас 1 өдрийн өмнө комиссын нарийн бичгийн даргад мэдэгдэх ба тус гишүүн нь нөхөж ажиллах боломжгүй байна.

5.7. Комисс барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлтийг хуралдаанаараа эцэслэн гаргахаас өмнө тухайн барилга байгууламжтай танилцан үзлэг хийж, ашиглалтад оруулахтай холбоотой асуудлыг комиссын хуралдаанаар хэлэлцэх бөгөөд зөрчил дутагдал илэрсэн бол түүнийг арилгуулахаар захиалагч, гүйцэтгэгчид үүрэг даалгавар өгнө.

5.8. Комиссын гишүүд хариуцсан асуудал тус бүрээр санал гаргана. Комиссын нийт гишүүдийн саналыг үндэслэн комиссын дүгнэлтийг гаргах бөгөөд уг дүгнэлтийг комиссын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

5.9. Комиссын гишүүд нь өгсөн санал, дүгнэлтийхээ биелэлтийг шалгаж, биелсэн тохиолдолд энэхүү дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулна.

5.10. Ашиглалтад оруулах комисс нь техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулах талаар дүгнэлт гаргана.

5.11. Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 хоногт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

5.12. Комиссын хуралдаанаар барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой асуудлыг нэгтгэн хэлэлцэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

5.12.1. барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж үзсэн тохиолдолд энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргана;

5.12.2. энэхүү дүрмийн 5.11-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд комиссын үйл ажиллагааг дахин зохион байгуулна.

5.13. Комисс энэхүү дүрмийн 5.10.1-д заасан дүгнэлтийг нийт гишүүдийн санал дүгнэлт болон энэхүү дүрмийн 5.9-д заасан үүрэг даалгаврын биелэлтийн баталгаажуулалтад үндэслэн гаргана.

5.14. Энэхүү дүрмийн 5.12.2-т заасны дагуу комисс дахин ажиллах бөгөөд холбогдох зардлыг Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.20-д заасны дагуу захиалагч хариуцна.

5.15. Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичгийг архивт хүлээлгэн өгч, Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7-д заасан мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг хүргүүлэх ажлыг захиалагч, гүйцэтгэгч хариуцна.

5.16. Комисс “Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссын дүгнэлт”-ийг баталгаажуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан тухайн нутаг дэвсгэрийн аймаг, нийслэлийн засаг даргад хүргүүлж, ашиглалтад оруулна.

5.17. Аймаг, нийслэлийн засаг дарга нь тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш ажлын 10 хоногт багтаан барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

5.18. Барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага барилга байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгох үйл ажиллагааг Барилгын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Захиалагч нь ашиглалтад оруулах комиссын гишүүдийн талаарх хууль бус үйлдлийг холбогдох хууль хяналтын байгууллагад гаргаж болно.

6.2. Ашиглалтад оруулах комисс, техникийн комиссын дүгнэлтийг хот байгуулалтын кадастрын цахим мэдээллийн санд оруулна.

6.3. Батлагдсан зураг төсөл болон холбогдох хууль дүрэм, журам, норм дүрмийн шаардлагад нийцэхгүй үүрэг даалгавар өгсөн тохиолдолд уг комиссын гишүүн гарах үр дагаврын хариуцлагыг хүлээнэ.

6.4. Ашигласан нь тогтоогдсон барилга байгууламжид комисс ажиллуулахыг хориглох бөгөөд энэ асуудлыг шүүхээр шийдвэрлүүлсний үндсэн дээр ашиглалтад оруулах комисс ажиллуулна.

6.5. Ашиглалтад оруулах байгууллага, захиалагч, барилгын ажил гүйцэтгэгч нь энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

-----oOo-----

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Барилгын тухай хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5*-д заасан төвөгшлийн барилга байгууламжийг /шинэ, өргөтгөл, шинэчлэл/ ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга:

Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагын барилгын асуудал хариуцсан нэгжийн дарга;

Нарийн бичгийн дарга:

Захиалагч байгууллагын төлөөлөл;

Гишүүд:

Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч);

Аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч);

Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (Барилгын тухай хуулийн 34.1.6¹³, 34.1.7¹⁴-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагын төлөөлөл);

Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл;

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл (тус бүр 1-ээс ихгүй);

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл;

¹³ 34.1.6.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

¹⁴ 34.1.7.барилгын салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

Архивын байгууллагын төлөөлөл.

Тайлбар 1. Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

Тайлбар 2. Энэхүү хавсралтын 1-д заасан "10.1.5" гэдгийг дүрмийн 3.6-д хамаарахаас бусад барилга байгууламж гэж ойлгоно.*

2. Барилга байгууламжийн гадна тохижилт, засвар, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга:	Захиалагч байгууллагын төлөөлөл;
Нарийн бичгийн дарга:	Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
Гишүүд:	Зураг төслийн байгууллагын төлөөлөл;
	Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл;
	Архивын байгууллагын төлөөлөл.

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

3. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан барилга байгууламж болон аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлтээр Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга:	Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (Барилгын тухай хуулийн 34.1.6, 34.1.7-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагын төлөөлөл);
Нарийн бичгийн дарга:	Захиалагч байгууллагын төлөөлөл;
Гишүүд:	Мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч);
	Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл (2-оос дээшгүй улсын байцаагч);
	Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах

байгууллагын төлөөлөл /барилга байгууламжийн хувьд/;

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл (тус бүр 1-ээс ихгүй);

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл;

Архивын байгууллагын төлөөлөл.

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

4. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан барилга байгууламж болон аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлтээр Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга:

Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын асуудал хариуцсан нэгжийн дарга;

Нарийн бичгийн дарга:

Техникийн комиссын дарга;

Гишүүд:

Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

Архивын байгууллагын төлөөлөл

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

5. Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга:

Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын асуудал хариуцсан нэгжийн дарга;

Нарийн бичгийн дарга:

Захиалагч байгууллагын төлөөлөл;

Гишүүд:

Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төв байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч);

Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (Барилгын тухай хуулийн 34.1.6, 34.1.7-т тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагын төлөөлөл);

Онцгой байдлын асуудал хариуцсан төв байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч);

Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл;

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл (тус бүр 1-ээс ихгүй);

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл;

Архивын байгууллагын төлөөлөл.

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

6. Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга:

Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын асуудал хариуцсан нэгжийн дарга;

Нарийн бичгийн дарга:

Техникийн комиссын дарга;

Гишүүд:

Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

Архивын байгууллагын төлөөлөл.

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 2 дугаар хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
ТЕХНИКИЙН КОМИССЫН ДҮГНЭЛТ

20 ... оны ... сарын ... -ны өдөр Дугаар
... Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын аймаг /нийслэл/,
сум /дүүрэг/, баг /хороо/-ны нутаг дэвсгэрт баригдсан
..... ангиллын хүчин чадал бүхий
зориулалттай барилга байгууламжид аймаг /нийслэл/-ийн
Засаг даргын 20 ... оны ... сарын ... -ны өдрийн дугаар шийдвэрээр байгуулагдсан
... хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн
комисс 20... оны ... сарын ... -ны өдрөөс эхлэн ...хоногийн хугацаанд ажиллан
тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний.....огноо,дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар

2.3. Захиалагч: /Иргэний хувьд/, харьяалал /аль
улсын/, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр,
..... регистрийн
дугаар, Хаяг: аймаг
/нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/,
..... гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас, цахим
хаяг;

/Хуулийн этгээдийн хувьд/: оноосон нэр,
..... Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Хаяг:
..... аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/,
. гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас, цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: оноосон
нэр, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар,
..... барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: аймаг /нийслэл/,сум /дүүрэг/, баг /хороо/, гудамж /хороолол/,байр /хашаа, хаалга/-ны дугаар, холбоо барих утас,цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:оноосон нэр,.....Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/, баг /хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны дугаар, холбоо барих утас,цахим хаяг;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:оноосон нэр,.....Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: аймаг /нийслэл/,сум /дүүрэг/, баг /хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны дугаар, холбоо барих утас,цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:оноосон нэр,.....Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/, баг /хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны дугаар, холбоо барих утас,цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал:

<input type="checkbox"/> Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах: - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул
<input type="checkbox"/> Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулахаас татгалзах: - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэ ангиллын.....хүчин чадал бүхий зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр техникийн комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. ангиллын хүчин чадал бүхий зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: _____()

Нарийн бичгийн дарга: _____()

***Энэхүү дүрмийн дөрөвдүгээр хавсралтын хамт хүчинтэй.

-----o0o-----

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ДҮГНЭЛТ

20 ... оны ... сарын ... -ны өдөр Дугаар ... Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын аймаг /нийслэл/,
сум /дүүрэг/, баг /хороо/-ны нутаг дэвсгэрт баригдсан
..... ангиллын хүчин чадал бүхий
зориулалттай барилга байгууламжид аймаг /нийслэл/-ийн
Засаг даргын 20 ... оны ... сарын ... -ны өдрийн дугаар шийдвэрээр байгуулагдсан
... хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 20...
оны ... сарын ... -ны өдрөөс эхлэн ...хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга
байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнийогноо,
.....дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар

2.3. Захиалагч: /Иргэний хувьд/, харьяалал /аль
улсын/, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр,
.....
..... регистрийн
дугаар, Хаяг: аймаг
/нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/,
..... гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас, цахим
хаяг;

/Хуулийн этгээдийн хувьд/: оноосон нэр,
..... Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Хаяг:
..... аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/,
..... гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас, цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: оноосон
нэр, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар,
..... барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: аймаг /нийслэл/, сум
/дүүрэг/, баг /хороо/, гудамж
/хороолол/, байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас, цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:Улсын
.....оноосон нэр,.....
бүртгэлийн гэрчилгээний дугаар, зураг төсөл
боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг:
аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/,
..... гудамж /хороолол/,
байр /хашаа, хаалга/-ны дугаар, холбоо барих утас,
.....цахим хаяг;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:Улсын
.....оноосон нэр,.....
бүртгэлийн гэрчилгээний дугаар, зураг төсөл
боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг:
аймаг /нийслэл/,сум
/дүүрэг/, баг /хороо/, гудамж
/хороолол/, байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас,цахим
хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:Улсын
.....оноосон нэр,.....
бүртгэлийн гэрчилгээний дугаар, зураг төсөл
боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: аймаг
/нийслэл/, сум /дүүрэг/,
баг /хороо/, гудамж /хороолол/,
.....байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас,цахим
хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал:

Гурав. Дүгнэлтийн хэсэг

<input type="checkbox"/> Барилга байгууламжийг ашиглалтад оруулах: - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул
<input type="checkbox"/> Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах: - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул - Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ ангиллын.....хүчин чадал бүхий
..... зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох

баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. ангиллын хүчин чадал бүхий зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: _____()

Нарийн бичгийн дарга: _____()

***Энэхүү дүрмийн дөрөвдүгээр хавсралтын хамт хүчинтэй.

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

/Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй/

Байгууллага:

Комиссын гишүүн:

Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар	Биелэлт
Үүрэг даалгавар өгсөн: Гарын үсэг: /Тамга, тэмдэг/ / / Гарын үсгийн тайлал Огноо:	Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: Гарын үсэг: /Тамга, тэмдэг/ / / Гарын үсгийн тайлал Огноо:

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ
ЖИШИГ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичиг
1	Төслийн үндсэн мэдээлэл
2	Зураг төсөл боловсруулах гэрээ
3	Зураг төсөл зохиогч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
4	Архитектур төлөвлөлтийн даалгавар
5	Техникийн нөхцөл бүрдүүлсэн тухай баримт бичгүүд
6	Газар олголтын захирамж
7	Геодезийн зураглалын ажлын тайлан
8	Магадлалаар баталгаажуулсан инженер-геологийн судалгааны дүгнэлт
9	Магадлалаар баталгаажуулсан ажлын зураг төсөл, төсөв
10	Зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт, хавсралтын хамт
11	Зохиогчийн хяналт хийх гэрээ
12	Барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг
13	Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
14	Захиалагч, гүйцэтгэгчтэй хийсэн гэрээ
15	Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
16	Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл
17	Барилгын ажлын ил, далд ажлын акт
18	Барилгын ажлын явцад барилгын улсын техникийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан дүгнэлт
19	Барилга угсралтын ажлын үе шат бүрт хяналт хийсэн тайлан, фото зураг
20	Барилгын материалын гарал үүслийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээ, лабораторийн дүгнэлт
21	Инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэсэн эсвэл өөрийн эх үүсвэр ашигласныг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл
22	Тоног төхөөрөмж угсарсан акт, холбогдох байгууллагаар баталгаажуулсан туршилтын баримт бичиг, зааврын дагуу суурилуулахад хийсэн туршилтын дүгнэлт
23	Зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт
24	Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт
25	Бусад холбогдох нэмэлт баримт бичгүүд